

Зам дээр бөртийх ганц хүн

/Хөрөг/

МУИС-ийн Утга зохиол судлалын 4-р түвшин М.Оюунбадам

Амьдралд хэзээ ч бууж өгөөгүй хүнийг түүнээс өөр би мэдэхгүй, тийм хүнтэй ахиж таарах ч үгүй биз. ухаан ороход минь ямар байсан яг л тиймээрээ.

Сум бүрээс аймгийн төв рүү, эсвэл аймгийн төвөөс сум бүр рүү цахилгаан дамжуулах утасны модод үргэлжилнэ. тэр утасны модыг дагаад аймаг орох зам заавал байна. Манай нутаг говь, тал газар болохоор мод гээд байх юм үгүй. ийм болоод ч тэр үү, би жинхэнэ ногоон моддоос илүү наранд хатаж хорчийсон, салхинд сонин дуугардаг шонгийн моддод илүү хайртай байдаг юм. зам даган эрийх тэр моддыг харахаар хаа нэг тийшээ явмаар ч юм шиг, эсвэл хаа нэгтээ намайг аваачих ч шиг сонин мэдрэмж төрнө. Ой дурсамжинд байх тэр моддын тухай бодох бүрий олон жилийн тэртээд хэдийн очно.

Говийн намар. Тэр их талыг туулах гэж хүн байтугай, нар ч өөрөө эцнэ. Эмээ бид хоёр утасны мод налан сууж, машины дуу чагнана. Хаа нэг салхинд шонгийн мод дуугарах нь машины дуутай яг андуурмаар. тэр болгонд би босч алсын бараа харна. Машиныг алдахгүй гэж салхитай өрсөнө. Амралтын өдрөөр далимдуулан замын унаанд дайгдан хөдөө гэртээ ирээд буцах гэж суугаа нь тэр. Халуун наранд эмээгийн сүүдэрт сууж сэрүүцнэ. Эмээ над шиг ядарлаа, халууцлаа гэхгүй. Харин зуны амралт болохоор би хөдөө гэртээ үлдэж, хурга ишиг эргүүлж ээж, аавдаа тус болно. Нэг удаа би саахны цагаар хургаа

хорингоо татуурганы усан дээр тоголж суутал, хариулж явсан хурга маань эхээдээ майлалдан давхиа харагдана. Ингэж нэг өдрийн саах тасалсан хэргээр хэзээ ч мартаггүйгээр аав ээждээ загнуулж билээ. Гомдсондоо хээр баахан уйлж, уйлахдаа эмээгээ улам их санана. Эмээ намайг загнаж, зандчиж байсныг бараг санадаггүй юм. Уг нь тийм ч дөлгөөхөн хүн бас биш л дээ. Зуны амралт дуусч өгөхгүй тэр өдрүүдийн уртыг нь яана. Ганц гэрээр зусдаг манайх шиг айлд хотоос хүн ирэхгүй л бол уйдаж үхэх шахдагсан. Тэгэх тусмаа эмээгээ санана. Ганцхан намайг л дагуулж айл хэсдгийг нь, ахын хөвгүүдээс өмөөрч өмгөөлдгийг нь, бас орой унтахын өмнө үлгэр яриж өгдөгийг нь, унтахынхаа өмнө хөлийг минь өхөөрдөж үнсдэгийг нь, юу ч үгүй шахуу болсон хөхөө надад үлгүүлдгийг нь санадагсан. Гэсэн ч эмээ минь ингэж бэтгэрсэн намайг мэдсэн шиг их л удалгүй аймгаас замын унаагаар долоо хоногтоо нэг ирээд буцчихна. Холоос “майхан”-ы арын зам дээр ганц хүн бөртөйтөл зогсож харагддагсан. Аав өмнөөс нь яваараа очиж авчирна. ингэж нэг хоёр сэтгэл дэвтэнэ.

Биеийг минь төрүүлсэн хүн бол миний ээж, харин өсгөж өндийлгөж, хүн болгосон нь аавын минь ижий, миний эмээ. Дүүг төрсний дараа хоёр ой дөнгөж хүрч байсан намайг эмээд минь өгөөд аймгийн төв рүү явуулж. би тэгэхэд хөхнөөсөө ч гараагүй байсан болохоор эмээ минь юм гарахгүй хөхөө надад үлгүүлсээр хүн болгосон юм гэдэг. Би багадаа эмээгийн хүүхэд байлаа. Эмээтэй хамт унтдаг, хаа л бол гараас нь хөтлөөстэй, дагаад айл хэсэх дуртай. Түүнтэй хамт өнгөрүүлсэн жилүүд хорин хэдэн насны минь хамгийн гэгээн, жаргалтай нь бөгөөд өлсөхийг, цангахыг, гэрээ санахыг, мөнгөгүй болохыг, зовохыг, өвдөхийг, ер нь юуг ч мэддэггүй, мэдэх ч хэрэггүй тийм л үе байлаа.

17-р жарны гал нохой жилийн өвөл чулуун гэх айлд нэгэн охин мэндэлсэн нь миний эмээ цэвэлправжаа билээ. Эмээ минь өвөрхангай аймгийн тарагт сумын хүн. Намдагийн “Хөгшин чоно ульсан нь” туужид гардагчилан хангай, говийн зааг нам дор газар. тарагтын тал, арвайн тал, үйзэн хүрэн, ар өвөр шанд, улаан лам гээд эмээгийн минь төрж, өссөн нутаг ус энэ билээ. Эмээ минь айлын хоёр дахь охин, дороо нэг эрэгтэй дүүтэй байж. Түүний аав чулуун их эрдэмтэй, идтэй лам хүн байсан гэдэг. Ямартай ч гурван хүүхдийнхээ хэтийн амьдралыг яг зөгнөж хэлсэн байгаа юм даа. Ганц хүүгээ сумын дарга болохыг үзэж чадаагүй хөөрхий хөгшин. Хүү нь өөрийнх нь хэлснээр насаараа дарга явсан хүн. Харин эмээг минь галын захаас холдохгүй хүн болох нь дээ хөөрхий гэсэн нь ч яг л таарч. Эмээгийн яриагаар бол аав нь түүнийг ор бараагүй, огтын чимээгүй байхад хэлмэгдэн арван жил шоронд суугаад гарч ирсэн гэдэг. Хамт ачигдсан нөхдийг нь хороосоор, өвгийн минь ээлж ирж 10- н жилийн хорих ял өглөө гэхэд нь учиргүй их баярлаж байсан тухай нь ээжээсээ сонссоноо эмээ минь ярьдагсан. Буурай ижийг минь барагцаагаар 4 настайд аав нь өөд болжээ. Багадаа сургуульд сурч байсан тухайгаа эмээ ярих их дуртай. Угтаа бол дөрөвдүгээр анги хүртэл л сурсан юм шүү дээ. Ар гэр нь хүн бүл муутай гэсэн учир аргагүйн эрхэнд гарсан гэнэлээ. Сургуульд уншиж, бичиж сурсаны ачаар ямар ч уран зохиолын номыг торохгүй уншдагсан. Чойномын “Сүмтэй будрын чулуу”-г дэрэн дороо хийж унтдаг байсныг нь санадаг юм. Тэрийгээ уншиж байхдаа намайг дуудан бас уншиж өгнө.

Хөрстийн амьдрал хөл алдсан

Хөлчүүхэн зүрхний минь тольтон дээгүүр

Шувууны сүүдэр шиг дайраад өнгөрсөн

Шунхан улаан залуу нас минь ... гээд л. Эмээ байсгээд л авдраа уудлахдаа залуу цагийнхаа зургаа гаргаж ирж харангаа, эмээ нь ийм хүүхэн явлаа шүү дээ гэж суудагсан.

Цэцэрлэгт анх орж байснаа санадаг юм. Тэнд л би хүний хамгийн хачин мөн чанарыг анх харж билээ. Багш эмээг минь ирэхээр надад учиргүй сайн хандаад эхэлнэ. Харин байхгүй болохоор нь загнаад унадагсан. Хүүхдүүд унтсаж, багш нар өрөөндөө орсон хойгуур би, хаврын салхинд цонхны цэцгэн хээтэй нимгэн цагаан хөшиг тавдугаар сарын сул салхитай хэрхэн эвцэхийг харж хэвтэх хамгийн дуртайсан. Ингээд эмээ гараас минь хөтөлж оруулсан шигээ гараас минь хөтөлсөөр цэцэрлэгээ дүүргэж билээ. Дараа нь би сургуульд оров. Сургуулийг би уран зургийн галарей шиг гэж төсөөлдөг байлаа. Уг нь би галарей орж үзээгүй л дээ. зурагтаар л харсан хэрэг. Тэр үед сургууль гурван ээлжээр хичээллэдэг байлаа. Миний хичээл дөрвөн цагаас ороод долоогоос тарна. хамгийн эхэнд уншчихаад л эмээгээ ирэхийг хүлээнэ. Тэр мөддөө ирэхгүй, заримдаа намайг таньдаг хүнээрээ намайг авхуулна. Өвөө минь тэр үед хэвтэрт орчихоод бие нь муу байснаас ингэдэг байсныг сүүлд нь мэдсэн. Намайг 2-р ангид байхад өвөө нас барлаа. Намайг эс тооцвол эмээ гань ганцаараа гэртээ үлдлээ. Эмээ өвөөг бурхан болсноос хойш бүр ч их тамхи татдаг болсон шиг одоо надад санагддаг юм. Буурай минь бага залуудаа мал маллаж ээж, эмээ, эгч, дүүтэйгээ амьдардаг байж. Дараа нь өвөөтэй ханилан аймгийн төвд ирж суун, нэгдсэн эмнэлэгт асрагчаар тэтгэвэрт гартлаа ажилласан гэдэг. Сургуульд сурч байснаа сав л хийвэл ярих дуртай энэ хүн төрсөн,

тэлсэн долоон хүүхэдтэй. уг нь арван нэг л дээ. Дөрвийг нь тэд нь бүгд охин байсан гэдэг. Тэгээд л энэ олон жилийн дараа том хүүгээс нь анхны охин нь төрөхөд өмчилж авсан нь би.

Буурай минь угийн хөрслөг бор хүн, өвдөнө гэж барагтай л үгүй, хууччуулын ярьдаг шиг жинхэнэ яс сайтай хүн дээ. Эр хүн шиг их биерхүү бас дээр нь ажилд их махруу, залхуу гэдгийг ер мэдэхгүй, хоол үлдээж идэхэд их дургүй нь дутуу дулимаг өссөн багынх нь амьдралтай л холбоотой биз ээ. Түүний амьдралыг үзэх үзэл их энгийн. Болно доо л гэж бодож, болгож ч ирсэн хүн. Энгийн, хайнга ганцхан үг шиг хэрнээ энэ үгний цаана асар их тэвчээртэй нэгэн хүний туулсан амьдрал харагдах шиг болдог юм. Түүнийг багад хавар, намрын хайлганд хөдөөний хүүхдүүд гуталгүй тул хөл нүцгэн хонь малдаа явдаг байж. Хөл нь даараад ирэхээр үхрийн халуун баас, шээсэн дээр гишгэж дулаацдаг байсан гэж ярих нь надад бол үлгэр мэт санагдана. Тэр энэ жил далан зургаан нас хүрч байгаа билээ.